Тайлант хугацаанд Хүнс, хөдөө аж ахуйн газрын санхүүгийн үйл ажиллагаанд дээд шатны байгууллагаас дотоод хяналт шалгалт хийгдээгүй байгаа тул дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А/385 дугаар тушаалаар хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн байгууллагуудын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 84,473.0 мянган төгрөгөөр буюу 76.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	15,691.6	26,118.5	10,426.9
Урьдчилгаа	7,200.0	-	(7,200.0)
Бараа материал	30,540.8	10,157.5	(20,383.3)
Үндсэн хөрөнгө	308,375.4	241,058.8	(67,316.6)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>361,807.8</b>	<b>277,334.8</b>	<b>(84,473.0)</b>
Өр төлбөр	15,691.6	17,765.6	2,074.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	346,116.2	259,569.20	(86,547.0)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>361,807.8</b>	<b>277,334.8</b>	<b>(84,473.0)</b>

Авлага дансны үлдэгдэл 10,426.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ХХААХҮЯ-аас олгосон 34,104.9 мянган төгрөгийн хүнсний ногооны үрийг аж ахуйн нэгж, иргэдэд хөнгөлөлттэй үнээр олгож, 23,677.9 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан

бол зарим аж ахуйн нэгж, иргэдийн хүнсний ногооны үрийн төлбөр төлөгдөөгүй үлдэгдэлтэй тайлагнагдсанаас шалтгаалсан байна.

2021 оны эцэст “Даталанд технологи” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу төсвийн хяналтын нэгдсэн [orengov.mn](http://orengov.mn) программын үйлчилгээний хөлсөнд 7,200.0 мянган төгрөгийг төлснөөр урьдчилж гарсан зардлын үлдэгдэлтэй тайлагдсан бол тайлант онд гэрээт ажлыг хэрэгжүүлсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 10,157.5 мянган төгрөг болж 20,383.3 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 30,891.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, ХХААХҮЯ-аас 198,629.3 мянган төгрөгийн хүнсний ногооны үрийг шилжүүлэн авсан болон 249,904.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл */анхны өртгөөр/* 610,362.6 мянган төгрөг болж 16,274.4 мянган төгрөгөөр өссөн нь ХХААХҮЯ-аас 16,274.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг балансаас балансад шилжүүлэн авснаас шалтгаалсан байна.

Тайлант оны эхэнд ХААДС-д өгөх хүнсний ногооны үрийн 15,691.6 мянган төгрөгийн өр төлбөртэй байсан бол тайлант онд санхүүжилт хүрэлцээгүйгээс “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ-т дулааны 2,074.0 мянган төгрөгийн өглөг нэмэгдсэнээр нийт 17,765.6 мянган төгрөгийн өр төлбөртэй тайлагнагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 259,569.2 мянган төгрөг болж 86,547.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 987,441.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт 657,224.7 мянган төгрөгөөр бууруулж, 330,217.1 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- Цалингийн зардлыг 34,061.7 мянган төгрөгөөр,
- Нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 4,257.6 мянган төгрөгөөр,
- Байр ашиглалттай холбоотой зардлыг 5,371.3 мянган төгрөгөөр,
- Хангамж, бараа материалын зардлыг 14,218.4 мянган төгрөгөөр,
- Нормативт зардлыг 2,464.7 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 62,433.8 мянган төгрөгөөр,
- Албан томилолтын зардлыг 9,565.8 мянган төгрөгөөр,

- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 13,845.7 мянган төгрөгөөр,
- Бараа, ажил үйлчилгээний бусад зардлыг 9,242.2 мянган төгрөгөөр,
- Нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлыг 1,913.5 мянган төгрөгөөр,
- Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 20,000.0 мянган төгрөгөөр,
- Мал аж ахуйг болон газар тариаланг хөгжүүлэх хөтөлбөрийн зардлыг 479,850.0 мянган төгрөгөөр тус тус бууруулсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд дараах зардлуудад төсвийн зохицуулалт хийж 652,772.5 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Үржлийн малд үзлэг, ангилалт хийх, ашиг шимийн үзүүлэлтийг тогтоох, цөм сүрэг бүрдүүлэх, баталгаажуулах зэрэг ажлыг зохион байгуулах зардлыг 286,077.0 мянган төгрөгөөр,
- Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангахад зориулсан зардлыг 6,000.0 мянган төгрөгөөр,
- Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, НДШ-ийн зардлыг 13,766.8 мянган төгрөгөөр,
- Байр ашиглалттай холбоотой зардлыг 3,668.2 мянган төгрөгөөр,
- Хангамжийн материалын зардлыг 4,088.3 мянган төгрөгөөр,
- Албан томилолтын зардлыг 2,235.3 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний зардлыг 14,577.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 7,857.8 мянган төгрөгөөр бууруулсан зэрэг.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 5 арга хэмжээний 652,772.5 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 652,772.5 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 645,709.9 мянган төгрөг буюу 98.9 хувьтай байгаа нь орон тоо дутуу ажилласнаас шалтгаалан цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 4,901.7 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 1,627.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнээс голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Мал аж ахуйг хөгжүүлэх	286,077.1	286,077.0	0.5	100.0
2	Газар тариалан хөгжүүлэх	6,000.0	6,000.0	-	100.0
3	Хөдөө аж ахуй, газар тариалангийн бодлого	341,153.8	334,277.7	6,876.1	97.9
4	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	1,600.0	1,600.0	-	100.0
5	Ажил олгогчоос олгох тэтгэмж	17,941.6	17,755.2	186.4	98.9
	<b>Дүн</b>	<b>652,772.5</b>	<b>645,709.9</b>	<b>7,062.6</b>	<b>98.9</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130019401 тоот дансанд нийт 41,278.7 мянган төгрөгийн дараах орлогуудыг төвлөрүүлж, 17,600.7 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулан, 23,678.0 мянган төгрөгийг татан төвлөрүүлжээ. Үүнд:

- Иргэд, аж ахуйн нэгжээс хүнсний ногооны үрийн 23,678.0 мянган төгрөгийг,
- Жижиг, дунд үйлдвэрлэлийн газраас хоршооны хөгжлийг дэмжих жилийн хүрээнд уг ажлыг сурталчлан таниулах зардалд 2,300.0 мянган төгрөгийг,
- Хөдөө аж ахуйн биржтэй байгуулсан гэрээний дагуу сумдын хоршоологчдын үйл ажиллагааг өргөжүүлэх, малчид хоршоодод сургалт зохион байгуулахад зориулан 8,000.0 мянган төгрөгийг,
- ХААДС-аас сумдын ургацын явц, мэдээтэй танилцахад зориулан шатахууны зардалд 3,000.0 мянган төгрөгийг,
- Засаг даргын нөөц хөрөнгөөс төвийн бүсийн аварга шалгаруулах ажил мэргэжлийн уралдаанд аймгийн тогоочдыг дэмжин оролцуулахад зориулан 2,860.7 мянган төгрөгийг, сумдад тариалангийн газрын тооллогыг зохион байгуулахад зориулан томилолтын зардалд 1,440.0 мянган төгрөг зэрэг.

Нэмэлт төсвийн орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторовын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Наранцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 14 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 468,592.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,685.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор дээд шатны төсвийн захирагчийн буюу ХХААХҮЯ-ны 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн “Төрийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллах тухай” 01 дүгээр албан даалгавар өгөгдсөн бөгөөд дараах зардлуудыг хэмнэсэн байна. Үүнд:

- Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох зардлыг 420.2 мянган төгрөгөөр,
- Нормын хувцас, зөөлөн эдлэл худалдан авах зардлыг 235.3 мянган төгрөгөөр,
- Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс худалдан авах зардлыг 471.8 мянган төгрөгөөр,
- Даатгалын үйлчилгээний зардлыг 865.9 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 183.3 мянган төгрөгөөр зэрэг.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Хүнс, хөдөө аж ахуйн газар нь мэдээлбэл зохих 20 нэр төрлийн 149 мэдээллээс 98 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, 51 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өглөө.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 03 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитын явцад дараах залруулгуудыг хийлээ. Үүнд:

- Шилэн дансанд мэдээлбэл зохих 20 мэдээллийг мэдээлээгүй зөрчлийг залруулж, холбогдох мэдээллийг нөхөн байршуулсан,
- Бараа материалын шинж чанартай 242.0 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд ангилал буруу бүртгэсэн,
- Бараа материал болон мөнгөн гүйлгээний дансны нийт 3,255.0 мянган төгрөгийн зарцуулалтыг зардлын эдийн засгийн ангилал буруу бүртгэсэн зэрэг.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 38,160.4 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна. Албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг аудитаар дахин хянахад 50.0 хувийн хэрэгжилттэй байна.

*Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	900.0	1	900.0	100.0
Зөвлөмж	1	38,160.4			
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>39,060.4</b>	<b>1</b>	<b>900.0</b>	<b>50.0</b>

Өмнөх онд өгөгдсөн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан

шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

ХХААХҮЯ, ХААДС-аас иргэн, аж ахуйн нэгжүүдэд эргэн төлөгдөх нөхцөлөөр 2021-2022 онуудад олгосон хүнсний ногооны үрийн тооцоолол тодорхой бус авлагыг барагдуулах үр нөлөө бүхий арга хэмжээ аваагүйгээс ХААДС-д 15,691.6 мянган төгрөгийн өр төлбөртэй тайлагнагдсан байна. Иймд дээрх хүнсний ногооны тооцоолол, авлага, өр төлбөрийн барагдуулалтыг дараагийн аудитаар тодорхой авч үзэх нь зүйтэй.

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой нийт 174,570.2 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Үндсэн санхүүжилтийн дансны 7,272.6 мянган төгрөгийн төвлөрүүлэг шилжүүлгийн дансны ангиллыг буруу бүртгэж, үр дүнг дутуу илэрхийлсэн,
- Ногооны үрийн хөнгөлөлтийн 136,419.7 мянган төгрөгийн үнэ төлбөргүй гарсан зардлыг үндсэн хөрөнгө худалдсаны гарз дансанд буруу бүртгэсэн,
- Өмнөх жилд orengov.mn программын үйлчилгээний хөлсөнд урьдчилан төлсөн 7,200.0 мянган төгрөгийн урьдчилж гарсан зардлыг тайлант онд зардлаар хүлээн зөвшөөрөөгүй,
- Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон ногооны үрийн авлагын эргэн төлөлтийн 23,677.9 мянган төгрөгийн орлогыг туслах үйл ажиллагааны орлого дансанд буруу бүртгэсэн,

Аудитаар нийт 5,002.4 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 450.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 4,207.8 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 344.6 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

#### **5.1 Төлбөрийн акт**

5.1.1 Үржлийн шилмэл сүрэг хоршоонд малын үзлэг ангилалтын ажлын санхүүжилтийг гэрээний үнийн дүнгээс **450.0** мянган төгрөгөөр илүү тооцож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил,

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон санхүүжилтийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

## **5.2 Албан шаардлага**

5.2.2 Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй **4,207.8** мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэсэн буюу зөрчлийг давтан гаргасан байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм ...” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэх.

## **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **5.3.1 Авлагын данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: ХХААХҮЯ болон ХААДС-аас аж ахуйн нэгж, иргэдэд хөнгөлөлттэй үнээр олгосон хүнсний ногооны үрийн тооцооллыг хянаагүй, авлагыг барагдуулах үр дүн бүхий арга хэмжээ аваагүй байгаа нь авлага төлөгдөхгүй байх эрсдэлийг үүсгэж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон үрийн тооцооллыг дахин хянаж, авлагыг барагдуулах үр нөлөө бүхий арга хэмжээ авах.

### **5.3.2 Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2 нэр төрлийн тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацааг тогтоож, элэгдлийн зардлыг тооцоогүй, ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч цаашид ашиглагдаж байгаа 20 нэр төрлийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг холбогдох газарт хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв

гаргах үндэслэл болно”, НБББББ-ийн “Үндсэн хөрөнгийн бүртгэлийн 5.4.7 дахь “Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох”, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т ирүүлж шийдвэрлүүлнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2 нэр төрлийн хөрөнгийн ашиглалтын хугацааг тогтоож, элэгдлийн зардлыг тооцох, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглаж байгаа хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн, холбогдох газарт хүргүүлэн шийдвэрлүүлэх.

### **5.3.3 Нэмэгдэл цалинтай холбоотой асуудал**

5.3.3.1 Илрүүлэлт: Тайлант онд “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-аар гүйцэтгэсэн ажлыг тодорхой тусгалгүйгээр аймгийн Засаг даргаас өгсөн чиглэлийн дагуу өргөдөл гомдлыг хууль тогтоомжийн хүрээнд судлан үзэж, шуурхай шийдвэрлэх ажлын хэсэгт ажилласан гэх үндэслэлээр илүү цагийн хөлсөнд 6 албан хаагчид нийт 344.6 мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 3.4 дэх “Төрийн албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын хавсралт хүснэгтийн үндэслэл хэсэгт 1.4.1-1.4.4, 1.5.1-1.5.2-т зааснаас тохирохыг сонгож бөглөнө. Ажлын товч агуулга гэсэн хэсэгт нэмэгдэл хөлс тооцох цагт гүйцэтгэсэн ажлын товч агуулгыг үндэслэл бүрээр бичнэ.” гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Илүү цагийн нэмэгдэл хөлсийг “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-аар гүйцэтгэсэн ажил тус бүрээр бичиж тайлагнаж байх.

5.3.3.2 Илрүүлэлт: Төрийн үйлчилгээний албан хаагчдын ур чадварын нэмэгдлийг ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэж бус оны эхэнд тушаал гаргаж, бүтэн жилийн турш олгож ирсэн байна. Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 3-д “Төрийн үйлчилгээний байгууллагын... албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу ... тооцож, сар бүр олгоно” гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн үйлчилгээний албан хаагчдын ур чадварын нэмэгдлийг ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу улирлаар дүгнэж, сар бүр олгож байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн үр дүнг дутуу илэрхийлсэн	1	7,272.6			1	7,272.6	1	7,272.6				
Үнэ төлбөргүй гарсан зардлын дансны ангилал буруу бүртгэсэн	1	136,419.7			1	136,419.7	1	136,419.7				
Урьдчилж гарсан зардлыг тайлант онд зардлаар хүлээн зөвшөөрөөгүй	1	7,200.0			1	7,200.0	1	7,200.0				
Орлогын дансны ангиллыг буруу бүртгэсэн	1	23,677.9			1	23,677.9	1	23,677.9				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>174,570.2</b>			<b>4</b>	<b>174,570.2</b>	<b>4</b>	<b>174,570.2</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
										Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо
Гэрээний үнийн дүнгээс илүү санхүүжилт олгосон	1	450.0	1	450.0							
Өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан	1	4,207.8			1	4,207.8					
Ногооны үрийн тооцооллыг хянаагүй	1						1				
Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоогүй, хөрөнгийг дахин үнэлээгүй	1						1				

Илүү цагийн хөлсийг батлагдсан маягтаар олгоогүй.	1	344.6					1	344.6			
Үр дүн, шалгуур үзүүлэлтийн дагуу ур чадварын нэмэгдлийг олгоогүй.	1						1				
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>5,002.4</b>	<b>1</b>	<b>450.0</b>	<b>1</b>	<b>4,207.8</b>	<b>4</b>	<b>344.6</b>			

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Хугацаа хоцроож мэдээлсэн	51							51
<b>Дүн</b>	<b>51</b>							<b>51</b>
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>	<b>51</b>							<b>51</b>